



ХЭНТИЙ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 09 сарын 28 өдөр

Дугаар А/43

Чингис хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:


1. Аймгийн хэмжээнд Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийн үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх шинэлэг санаачилгын "Иргэний оролцоотой шинэ Хэнтий" зөвлөгөөнийг 2018 оны 10 дугаар сарын 11-ний өдөр Чингис хотод зохион байгуулсугай.

2. Зөвлөгөөн зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч	Ж.Гантулга	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга	Д.Ганболд	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн
Гишүүд	Ж.Даваасүрэн	Тогтвортой амжиргаа-3 Орон нутгийн төслийн ажилтан
	С.Нямдаваа	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	Э.Мөнх-Эрдэнэ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
	Г.Лхагвахатан	Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
	Л.Бат-Октябрь	Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
	Ч.Баярцолмон	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга

2. Зөвлөгөөн зохион байгуулах ажлын нарийвчилсан хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан батлуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Ж.Гантулга/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР